

Төлбөрийн муж тогтоох тухай

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН

ТУШААЛ

2013 оны 11 дүгээр сарын 13 өдөр

Улаанбаатар хот

Дугаар 325

Төлбөрийн муж тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.1, Ойн тухай хуулийн 13.1.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр тогтоох мужлалын хилийн заагийг хавсралтын ёсоор баталсугай.
2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Байгаль орчны сайдын 1996 оны "Төлбөрийн мужийн хилийн заагийг тогтоох тухай" 230 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Сайд

С.ОЮУН

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын

2013 оны 11 дүгээр сарын 13 - ны өдрийн

325 дугаар тушаалын хавсралт

**ОЙГООС ХЭРЭГЛЭЭНИЙ МОД, ТҮЛЭЭ БЭЛТГЭЖ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР
ТОГТООХ МУЖЛАЛ**

Нэгдүгээр муж

1. Монгол улсын ойн сангийн хамгаалалтын бүсийн бүх ой:
2. Монгол Алтайн нурууны ой:
3. Баянхонгор, Өвөрхангай аймгийн ой

Хоёрдугаар муж

Увс, Завхан, Архангай, Дорнод аймгийн ашиглалтын бүсийн ой.

Гуравдугаар муж

Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймгийн ашиглалтын бүсийн ой.